



МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

СОЁМБО МЭДЭЭ

№34 /478/

2023.02.17

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

"БААТАРЛАГ ҮЙЛСТЭН"-ЭЭР ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ ШАЛГАРЛАА

МҮОНРТ-ийн "Монголын мэдээ" суваг сар шинийн баярыг угтан "Цагийн хүрдийн баатрууд"-аа алдаршуулдаг уламжлалтай. Тэгвэл "Сайжруулагч" хэмээх Усан бар жилийн "Баатарлаг үйлстэн" номинацид Цэргийн төв эмнэлгийн хамт олон шалгарлаа. Энэ талаар Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч хурандаа Б.Энх-Одоос тодрууллаа.

"Баатарлаг үйлстэн" номинацад шалгарсанд баяр хүргэе. Эмнэлгийнхээ онцлогийг товч тодорхойлооч гэвэл та юуг онцгойлох вэ?

-Баярлалаа. "Монгол Улсад тангараг өргөдөг цөөн тооны мэргэжил байдаг ч цэргийн эмч нар шиг хосоор нь өргөдөг тохиолдол байхгүй. Мөн Цэргийн төв эмнэлэг бол Монгол Улсдаа анхныхад тооцогдох Шинжлэх ухааны эмнэлэг юм. Тэр ч утгаараа манай Цэргийн төв эмнэлгийн алба хаагчдад маш өндөр үүрэг, хариуцлага оногддог. Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд цэргээ илгээж эхэлснээс хойших 22 жилийн хугацаанд Цэргийн төв эмнэлгийн алба хаагчид тогтмол үүрэг гүйцэтгэж бие бүрэлдэхүүний төдийгүй ажиллагааны газар орны иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд хүчин зүтгэсээр ирсэн. Мөн Монгол Улсад тохиолдож байсан гамшигт үзэгдлүүд, тахал, өвчлөлийн үед манай цэргийн эмч нар үнэтэй хувь нэмэр оруулж хүн ардаа сахин хамгаалах үйлсэд манлайлан ажилласаар ирснийг хэлэх нь зүйтэй байх. Онцлоод байвал олон зүйлийг хэлж болно.

Монгол Улсын 2022 оны тэргүүлэгч байгууллага гэж нэрлэж болохуйц шагналыг хүртэхэд БНТУ-д үүрэг гүйцэтгэж буй бие бүрэлдэхүүний гавьяа ихээхэн байсан нь ойлгомжтой.

-Тэгэлгүй яах вэ. Энэ цаг мөчид ч Цэргийн төв эмнэлгийн эмч нараас бүрдсэн 3 бүлэг БНТУ-д болсон газар хөдлөлтийн халуун цэгт орон нутгийн иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлэх хүмүүнлэгийн үйлсэд хүчин зүтгэсээр байна. Тухайлбал, Гэмтэл яаралтай тусламжийн хоёр баг, Мэс засал мэдээгүүжүүлгийн нэг багийг тоног төхөөрөмжийн инженер, тэднийг удирдах алба хаагчдын хамтаар БНТУ руу илгээсэн.



Манай эмч нар БНТУ-д үүрэг гүйцэтгэх бэлтгэл ажлыг 15 цагийн дотор хангаж ажиллагааны газар оронд газардсан даруйдаа хоёр иргэний амь насыг аварч, яаралтай тусламж үйлчилгээг үзүүлсэн. Урьд өмнө ийм томоохон

хамгийн ихээр сүйдсэн Турк, Сирийн хил дээр буюу халуун цэг дээр нь ОБЕГ-аас тусдаа байрлаж үүрэг гүйцэтгэж эхэлсэн. Манай алба хаагчдын мэдээлснээр тухайн газар нутагт эмч, эмнэлгийн тусламж барилга

ажиллагаа явуулж 595 иргэнд /63 хүүхэд/ төрөл бүрийн тусламж, шаардлагатай эмчилгээг хийгээд байна. Нарийвчлан авч үзвэл гэмтлийн яаралтай тусламжийг 311, дараагийн шатны эмчилгээ хийлгэх шаардлагатай 29 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсний зэрэгцээ 95 удаагийн их, бага



ажиллагаанд ийм богино хугацаанд бэлтгэл ажлыг хангасан тохиолдол Цэргийн төв эмнэлгийн түүхэнд хувьд байнгын бэлэн байдалд, ямар ч нөхцөлд үүрэг гүйцэтгэх боломж бололцоотой гэдгийг батлан харуулсан явдал байлаа. Мэдээж эхлэлээс авхуулаад ажиллагааны газар оронд төвхнөх хүртэл амар хялбар байгаагүй. Жишээлбэл манай цэргийн хээрийн эмнэлгийн бие бүрэлдэхүүн Улаанбаатар хотоос 9 цаг 30 минут гаруй нислэг үйлдэж Туркийн Газантип хотод газардаад тэндээсээ 200 км газар марш үйлдэж газар хөдлөлтийн гамшигт

байгууламжийн 90 хүртэлх хувь нь бүрэн сүйдсэн ийм нөхцөл байдалтай байсны зэрэгцээ анхлан байрлахаар шийдвэрлэсэн газрын ойролцоо Сирийн дүрвэгсдийн хуаран оршиж байсан учраас аюулгүй байдал гэдэг үүднээс 20 км татаж Хатай мужийн Антакья хотод үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

БНТУ-д үүрэг гүйцэтгэж буй бие бүрэлдэхүүн одоогоор хэчнээн иргэнд тусламж үйлчилгээг үзүүлээд байна вэ?
-Одоогоор Монгол Улсын Зэвсэгт хүчний Цэргийн хээрийн эмнэлгийн бие бүрэлдэхүүн 10 дахь өдрөө тасралтгүй үйл



хагалгааг амжилттай хийж гүйцэтгэсэн. Энэ бол гуравхан бүлгийн хувьд их тоо юм. Тэр хэрээр алба хаагчид маань шаргуу, ачаалалтай ажиллаж байгаа. Нэмж хэлэхэд БНТУ-д үүрэг гүйцэтгэж буй эмч нарийн хувьд хамгийн багадаа 2-3 удаа гамшигийн болон ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэсэн туршлагатай. Тийм ч учраас Цэргийн төв эмнэлэг уг газар оронд алба хаагчдаа илгээхдээ итгэлтэй байсан төдийгүй алба хаагчид маань тэр итгэлийг алдаагүй. Харин ч бүр давуулан биелүүлж байгаа нь гайхамшигтай.
Газар хөдлөлтийн гамшиг нүүрлээд багагүй хугацаа өнгөрлөө. Цаг явах тусам амьд гарах иргэдийн тоо улам багасах нь мэдээж...
-Харамсалтай нь тийм. Үүрэг

гүйцэтгэж эхэлсэн эхний 2-3 хоногт нурангиас татан гаргасан иргэдийн дараалал тасраагүй ч цаг хугацаа өнгөрөх тусам энэ тоо улам багасах хандлага ажиглагдаж байна. Сүүлийн 2 хоногт ирүүлсэн иргэдийн мэдээллийг харахад эрэн хайх, аврах, татан гаргах үйл ажиллагаанд оролцож яваад бэртсэн эсхүл сэтгэл санааны хүнд цочролд орсон хүмүүс түлхүү ирж байна.

Та үүрэг гүйцэтгэж буй Монголын цэргийн хээрийн эмнэлгийн бие бүрэлдэхүүн болон тусалцаа дэмжлэг үзүүлсэн хүмүүсд хандаж юу гэж хэлэх вэ?

-БНТУ-ын иргэдтэй холбоо тогтоох болон үйл ажиллагаа явуулах нөхцөл байдлыг бүрдүүлэхэд ихээхэн тусалцаа үзүүлсэн Монгол Улсаас БНТУ-д суугаа Батлан хамгаалахын атташе хошууч генерал Ж.Бадамбазар, БНТУ-д үүрэг гүйцэтгэж буй цэргийн хээрийн эмнэлгийн нийт бие бүрэлдэхүүн болон түүнийг ахлан яваа Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн захирагч хурандаа Ж.Сүх-Очир, Цэргийн төв эмнэлгийн Аврахуйн Анагаах ухаан эрхэлсэн орлогч дарга дэд хурандаа Л.Лувсандорж нарт Монгол Улсын Зэвсэгт хүчин, цэргийн эмч нарын нэр хүндийг олон улсын тавцанд өндрөөр өргөж яваад чин сэтгэлийн талархал илэрхийлэе.

Мөн Цэргийн төв эмнэлгийн үе үеийн дарга нараа бас дурдах зүйтэй. Учир нь эдгээр хүмүүсийн зааж сургасан, хийж хэрэгжүүлсэн зүйлсийн ачаар бид бүхэн өдий зэрэгтэй яваа. Ташрамд дуулгахад БНТУ нь дөрвөн армитай бөгөөд түүний нэг болох Өмнөд армийнхан командлагч дэслэгч генерал Кемал Еэни манай эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, эмч ажилчдад маань талархал илэрхийлээд явсныг дуулгая. Ямартай ч Монгол Улсын Цэргийн төв эмнэлгийн бие бүрэлдэхүүн БНТУ-д үүрэг гүйцэтгэж эхэлснээс хойш нутгийн иргэдийн талархлыг ихэд хүртэсний зэрэгцээ дэлхий нийтийн томоохон хэвлэлүүдээр ч манайхыг онцолж байгаа мэдээлэл цахим орчинд түгээд байна. Энэ бол манай чадварлаг залуусын ач гавьяа, хичээл зүтгэл юм шүү гэдгийг дахин дахин хэлмээр байна.
Ө.НАСАНТОГТОХ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-6	-29

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,515	3,521
EUR	3,782	3,803
CNY	510	513
RUB	46.10	46.70
JPY	26.60	26.80
KRW	2.75	2.78

ЗУРХАЙ



ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ УЛААН МОРЬ ӨДӨР

Үс засуулбал: Өлзийтэй сайн НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 07.56-18.17 БАРИЛДЛАГА: Идэр ШҮТЭН БАРИЛДЛАГА: Хуран үйлдэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдвэр үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясгалын хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 677,940,157

Эдгэрсэн

Нийт: 650,524,905

Нас барсан

Нийт: 6,784,511

Цахим шууданд

649 ИРГЭНД ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖЭЭ



БНТУ-ын Хатай муж Антакья хотод дэлгэсэн Цэргийн төв эмнэлгийн цэргийн хээрийн II шатны эмнэлэг 2023 оны 02 сарын 16-ны 08.00-14.00 цаг хүртэл гамшигт нэрвэгдсэн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж, гэмтлийн болон бусад шалтгаант нийт 54 иргэнд /7 хүүхэд/ тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Тусламж, үйлчилгээгээр давтан боолт хийлгэхээр 15, гар болон хөлийн зүсэгдсэн шарханд оёдол тавьж, гарын сарвуу хэсгийн түлэгдэл зэрэг гэмтлийн тусламж үйлчилгээг 12 хүнд үзүүлсэн бөгөөд амьсгалын дээд замын халдварт өвчин, хоол боловсруулах замын хямрал, халдварт өвчний асуумж бүхий 15 өвчтөнд шингэн сэлбэх болон эмийн эмчилгээ хийж биеийн байдлыг нь тогтворжуулан зөвлөгөө

өгч давтан хяналт хийхээр буцаасан байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах иргэд цаг харгалзахгүй ирж байгаа ч орон нутгийн эмч, эмнэлгийн ажилчид шилжин ирсэнтэй холбогдуулан Цэргийн төв эмнэлгийн цэргийн хээрийн II шатны эмнэлгийн үйл ажиллагааг 14 цагт зогсоож эмнэлгийг хурааж ачиж, тээвэрлэхэд бэлэн болжээ. Мөн эмчилгээ үйлчилгээнээс үлдсэн, шаардлагатай эм тариа, эмнэлгийн хэрэгсэлийг Турк Улсын Тусгай хүчний штабын даргад хүлээлгэн өгч эмнэлгийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад дэмжлэг үзүүлээ. Эмнэлэг дэлгэн ажиллаж эхэлснээс хойш нийт 649 өвчтөнийг хүлээн авч эмчилгээ, үйлчилгээ явуулсан байна.

АХМАД ДАЙЧИН Д.СЭРЧИН-ОЙДОВТ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Өдгөө 100 насны босгыг алхаад буй ахмад дайчин, чөлөөнд байгаа дэд хурандаа Д.Сэрчин-Ойдовт Сар шинийн баярыг тохиолдуулан ЗХЖШ-аас хүндэтгэл үзүүлээ. Энэ үеэр ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах "Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хөгжлийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж, залуу хойч үеэ цэрэг-эх оронч үзлээр сурган хүмүүжүүлэхэд оруулсан хувь нэмрийг тань бид үргэлж санаж явдаг. Танд болон танай гэр бүлд "Үзэсгэлэн боллогч" хэмээх усан туулай жилдээ эрүүл энх, аз жаргалаар дүүрэн байхын ерөөлийг дэвшүүлье" хэмээв. Чөлөөнд байгаа дэд хурандаа Д.Сэрчин-Ойдов нь Зэвсэгт хүчиндээ 50 гаруй жил ажиллахдаа БХЯ, ЗХЖШ болон 5 дугаар армийн Газрын зургийн албаны даргаар ажиллаж байгаад цэргийн тэтгэвэрт гарч байжээ.

СОНСОГЧ НАР "НОМЫН САЙН НӨХӨР" АЯН ӨРНҮҮЛЖ БАЙНА



Батлан хамгаалах удирдлагын академийн "Мэдлэг бүтээгч" номын клуб нь ҮБХИС-ийн сонсогчдыг ном бүтээлчээр унших аргаар сэдэлжүүлэх, багаар ажиллах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх хүрээнд "Номын сайн нөхөр" аяныг өрнүүлж байна.

Аяны хүрээнд тус клубийн сонсогч офицерууд ҮБХИС болон Батлан хамгаалах удирдлагын академийн Номын санд баяжилт хийж, уран зохиол, цэргийн шинжлэх ухаан, түүх, гадаад хэлний ном, сэтгүүлийн хандив өргөлөө.

Тус клубийнхэн сонсогчдыг номтой нөхөрлүүлэх, эерэг хандлагыг бий болгохын зэрэгцээ нийтийн ном уншлагыг идэвхжүүлэх зорилгоор олон арга хэмжээг зохион байгуулж байгаагийн нэг нь энэхүү аян юм.

Хошууч Б.ЭНХБАЯР

Гэрэл зураг-нэг агшин



Мэргэжилдээ эзэн нь болж Мэдлэг, чадвараар ямагт манлайлна.

ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙНХЭН ХОЁР ОФИЦЕРЫНХОО ГЭРГИЙ НАРТ 43 САЯ ТӨГРӨГИЙН



Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч, дэд хурандаа Д.Батсайханы гэргий Н.Эрдэнэцэцэг, Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Сургалтын албаны дарга, хошууч П.Отгонбаатарын гэргий Д.Солонго нар маш хүнд өвдөж, гадаадад хагалгаа, эмчилгээ хийлгэх болсонтой холбогдуулан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас сайн үйлсийн аяныг Зэвсэгт хүчний хэмжээнд амжилттай өрнүүлээ.

"Мөрдөс нэгт нөхрийнхөө гэргийг мөрөөс нь түшээд босгоё, бүгдээрээ" хандивын аянд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нэгтгэл ангиуд, мэргэжил нэгт нөхөд, онжавууд, сайхан сэтгэлт иргэд идэвхтэй оролцож, тусламжийн гараа сунгасанд офицеруудынхаа нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлэе.

Хандивын аянд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Зэвсэгт хүчний 014, 119, 120, 123, 167, 186, 234, 256, 326, 327, 336, 338 дугаар ангиудын сайхан сэтгэлт хамт олон нэгдэж, эмчилгээний зардалд нэмэр болох үүднээс 43 сая төгрөг хандивласан бөгөөд хоёр офицерынхоо гэргийд хуваан шилжүүлж, хурдан эдгэхийг хүсэн ерөөсөн юм.

Мөн БХЯ-ны ГХАГ-ын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ болон хурандаа П.Чинзориг, С.Баяр-Очир, Д.Батзориг, Ш.Уртнасан нарын цэргийнхнээс эхлээд дэд хурандаа

Д.Батсайхантай нэгэн цагт хамт ажиллаж байсан Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн журмын нөхөд, хошууч П.Отгонбаатартай хамт ажиллаж байсан Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн журмын нөхөд нь тус тус тусламжийн гараа сунгасан билээ.

Ханийнхаа хамтран зүтгэгч мөрдөс нэгт нөхдийнх нь энэрэнгүй сайхан сэтгэлд дэд хурандаа Д.Батсайхан, хошууч П.Отгонбаатар нарын гэргий нар талархлаа илэрхийлж "Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн удирдлага, нийт бие бүрэлдэхүүнд маш их баярлаж байна. Та бүхнийхээ сэтгэлийн гал, итгэлийн хүчээр бид удахгүй хөл дээрээ босож, эрүүл энх болон оо. Дайны голомтод нөхрөө хаяж зугтдаггүй шиг өвдөж шаналсан офицеруудынхаа гэргий нарт тусалж байгаа үйлсэд нь талархаад баршгүй" гээд ажил, албанд нь өндөр амжилт хүссэн юм.

Ташрамд дурдахад, дэд хурандаа Д.Батсайханы гэргий Н.Эрдэнэцэцэг БНХАУ-ын цэргийн эмнэлэгт хагалгаандаа амжилттай орж, хошууч П.Отгонбаатарын гэргий Д.Солонго БНТУ-ын эмнэлэгт эмчилгээгээ эхлүүлээд байна.

Үйлс, зорилго нэгтэй офицеруудынхаа аз жаргалтай гэр бүлд элэг бүтэн амьдрал бэлэглэхэд нэгдэж, хандив өргөсөн сайхан сэтгэлт иргэд, мөрдөс нэгт нөхөдөө талархал дэвшүүлье!

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!
ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

Өнөөдрийн эшлэл үг



Израилын ерөнхий сайд ГОЛДА МЕЙР:

Охид хөвгүүд нь эргэж ирдэг, ард иргэд нь гадагшаа зөвхөн амрахаар л явдаг, ирээдүйнхээ төлөө сэтгэл зовох зүйлгүй тийм улсыг байгуулъя гэвэл хоёрхон зүйлийг л хийх хэрэгтэй.

Үүнд:

- Авлига авах явдлыг эх орноосоо урвасантай адилтган урвагч гэж үзэх;
-Цэргийнхэн, багш болон эмч нарын мэргэжлийг хамгийн нэр хүндтэй бөгөөд хамгийн өндөр цалинтай болгох;
Үүний сацуу хөдөлмөрлө, хөдөлмөрлө, хөдөлмөрлө...
Учир нь та нарыг та нараас өөр хэн ч хамгаалахгүй, мөн хэн ч тэжээж тэтгэхгүй. Улс орон чинь та нарт л хэрэгтэй, өөр хэнд ч хэрэггүй. Энэ бүхэн хий хоосон үг, уриа лоозон төдий байхаа больж амьдрах хэв маяг чинь болсон цагт л та нар зорьсондоо хүрнэ...